

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АЛТАЙ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.11.15

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцомын баталсан 2021 оны 10 дүгээр сарын 25-ны өдрийн өдрийн ИНЕГ-ын харьяа Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 27/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ын аудитор О.Сэндэр, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг зайнаас хийсэн.

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцомын баталсан удирдамжийн хүрээнд Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7-д заасны дагуу ИНҮТ-ийн Нисэх буудлын үйлчилгээний газар тус нисэх буудлын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаагүй, хагас жилээр үнэлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу даргын тушаалын биелэлтийг зөв үнэлдэггүй.

Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гаргасан тушаал шийдвэрүүдийг шалгахад тушаалын үндэслэл хэсэгт хууль, дүрэм журмын заалтыг буруу бичих, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөөгүй зэрэг зөрчлүүд байна.

Цаг бүртгэлийн цахим бүртгэлийг ямар нэг шийдвэргүйгээр ашиглахгүй байгаа нь ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг зөрчиж байна. Мөн хурууны хээг уншуулахгүйгээр нүүр царайгаа таниулан цаг бүртгэлээ хийх боломжтой байхад дотоод боломжоо ашиглаагүй байна.

Нисэх буудлын нислэгийн удирдагчийн зэргийн нэмэгдлийн хугацаа дууссан байхад нэмэгдэл хөлс олгосон.

Бараа материалыг бүртгэлд тусгахдаа барааны бүлгийг буруу бүртгэсэн байна.

Хөрөнгө мөнгө зарцуулах гэрээнүүдийг оруулаагүй ба энэ гэрээнүүдийн дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл дутуу оруулсан.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 1, нисэх буудалд 12, нийт 13 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА